# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. | Дугаар 01 | Улаанбаатар хот.

Хурлын тэргүүлэгчид
батлах тухай.

**ТОГТООХ нь**:

1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх ээлжит хурлын тэргүүлэгчдийг хувь нийлүүлэгчдийн саналыг үндэслэн доорх бүрэлдэхүүнтэй баталсугай.

   Хурлын тэргүүлэгчдийн дарга: Л.Шагдаррагчаа
   Гишүүд Б.Бурмаа
   Ш.Эрдэнэбат

2. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг удирдан зохион байгуулахыг хурлын тэргүүлэгчдэд зөвшөөрсүгэй.

Хурал зохион байгуулах ажлын хэсгийн дарга. Ш.Эрдэнэбат.
В.Мөнхгэрэл
Д.Гэрэлцэцэг

# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. Дугаар 02 Улаанбаатар хот.

Хэлэлцэх асуудлыг
батлах тухай.

**ТОГТООХ нь:**

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаар доорх асуудлыг хэлэлцсүгэй.

1. ТУЗ-ийн тайлан
2. 2009 оны компанийн үйл ажиллагааны тайлан, 2010 оны үйл ажиллагааны чиглэл
3. 2009 оны санхүүгийн тайлан
4. Хянан шалгагчийн тайлан
5. ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчийг улируулан томилох тухай
6. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг батлах тухай
7. Бусад асуудал, мэдээлэл

Хурлын тэргүүлэгчдийн

Дарга. Л.Шагдаррагчаа

Гишүүд. Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат

# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. Дугаар 03 Улаанбаатар хот.

Хурлын дэг
батлах тухай.

**ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн тайлан – ТУЗ-ийн дарга Л.Шагдаррагчаа – 10 минут
2. 2009 оны компанийн үйл ажиллагааны тайлан, 2010 оны үндсэн чиглэл – Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэбат – 10 минут
3. 2009 оны санхүүгийн тайлан – Ерөнхий санхүүч Д.Гэрэлцэцэг – 10 минут
4. Хянан шалгагчийн тайлан – Хянан шалгагч С.Тунгалаг – 5 минут
5. ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчийг улируулан сонгох тухай – цаг тогтоохгүй.
6. Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас гарах шийдвэрүүдийг батлах тухай – Цаг тогтоохгүй
7. Бусад асуудлын мэдээлэл – Цаг тогтоохгүй.
8. Санал шүүмжлэл – Хүн бүр 3 минут
9. Хурлыг 2010 оны 04-р сарын 23-ны өдрийн $10^{00}$ цагаас эхлэн цаг тутам 15 минутын завсарлагатай хийж $14^{00}$цагт дуусгана.

Хурлын тэргүүлэгчдийн

Дарга. Л.Шагдаррагчаа

Гишүүд. Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат

# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. | Дугаар 04 | Улаанбаатар хот. |

Тайлангууд батлах тухай.

“Барилга” корпораци ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2009 оны үйл ажиллагааны тайлан, 2010 оны үйл ажиллагааны үндсэн чиглэл, ТУЗ, Хянан шалгагчийн хэлэлцүүлсэн тайланг баталсугай.

2. Тус корпорацийн 2009 оны санхүүгийн тайланг баталсугай.

3. ТУЗ-д даалгах нь:

а/ 2010 оны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн нарийвчилсан төлөвлөгөөг 2009 оны 05-р сард багтаан хянаж батлах;
б/ Компанийн өр авлагыг барагдуулах идэвхитэй үйл ажиллагааг хэрэгжүүлэх;
в/ “Оюу толгой” төслийн К-524 тоот гэрээний хэрэгжилтийг хянаж удирдлагаар хангах;
г/ “Намуун дэнж” төслийн барилгыг гүйцээн худалдах, банкны зээл хүүг хүндрэл учруулахгүйгээр 3-р улиралд багтаан төлж барьцаа хөрөнгө чөлөөлөх асуудлыг 5-р сард багтаан шийдвэрлэх;

4. ТУЗ, Хянан шалгагчид даалгах нь:

а/ Компанийн жил, улирлын тайлан балансад дүн шинжилгээ хийж ажиллах;
б/ Санхүүгийн тайлан балансын орлого, зарлага, ашигт дүгнэлт хийх;
в/ Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын шийдвэрт хяналт тавих;

Хурлын тэргүүлэгчдийн

Дарга. Л.Шагдаррагчаа
Гишүүд. Б.Бурмаа
Ш.Эрдэнэбат

# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

| | | |
|---|---|---|
| 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. | Дугаар 05 | Улаанбаатар хот. |

ТУЗ-ийн гишүүд, хянан шалгагчийг батлах тухай.

Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлын 2010 оны 04-р сарын 23-ний өдрийн шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Барилга” корпораци ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга гишүүдийг болон Хянан шалгагчийг хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийг үндэслэн 100 хувийн саналаар доорх бүрэлдэхүүнтэй улируулан сонгож баталсугай.

| | |
|---|---|
| Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга | Л.Шагдаррагчаа |
| Гишүүдэд | Ш.Эрдэнэбат |
| | Б.Бурмаа |
| | Ш.Үнэнбат |
| | Ж.Жадамба |
| | Ш.Ариунбат |
| | Н.Жадамба |
| | Ш.Төгсбат |
| | Б.Энхболд |

2. Корпорацийн хянан шалгагч С.Тунгалаг

**Хурлын тэргүүлэгчдийн**

**Дарга.** Л.Шагдаррагчаа

**Гишүүд.** Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат

# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. Дугаар 06 Улаанбаатар хот.

Ашгийн хуваарилалтын тухай.

“Барилга” корпораци ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Барилга” корпорацийн 2009 оны балансын дүнгээр оны эцэст 11.000.000 төгрөгийн алдагдалтай гарсан тул хувьцааны ногдол ашиг, ТУЗ-ийн гишүүд, аппаратын ажилчдын шагнал хуваарилахгүй байхаар тогтоосугай.

Хурлын тэргүүлэгчдийн

Дарга. Л.Шагдаргачаа

Гишүүд. Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат

# “БАРИЛГА” КОРПОРАЦИ ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр. Дугаар 07 Улаанбаатар хот.

Удирдлагын зардал
батлах тухай.

**ТОГТООХ нь:**

“Барилга” корпораци ХК-ийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлаас **ТОГТООХ нь:**

1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинг нэг удаагийн хуралд
   - ТУЗ-ийн дарга - 80,000 төгрөг
   - Гишүүдэд - 50,000 төгрөг
   - Хурлын зардалд - 10,000 төгрөг

   Хянан шалгагчийн цалинг шалгалт дүгнэлт бүрт 50,000 төгрөгөөр тооцож олгож байхаар тогтоосугай.

2. Удирдлагын зардлын жилийн дүнг 2.420.000 төгрөгөнд багтаан зарцуулж байхыг ТУЗ-д зөвшөөрсүгэй.

Хурлын тэргүүлэгчдийн

Дарга. Л.Шагдаррагчаа

Гишүүд. Б.Бурмаа

Ш.Эрдэнэбат